

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Баруун-Урт сумын 1-р баг "24 айл", "60 айл" орчмын гадна зам талбай, Грийн таун хорооллын баруун талаас музейн урд талын 2-р тойргийн зам хүртлэх авто замын ажил.

Ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд:

1. Ажлыг гүйцэтгэх явцад технологийн үе шат бүрт гүйцэтгэсэн ажлыг шалгуулж, техникийн шаардлага бүрэн хангагдсан гэж үзвэл холбогдох газруудаас зөвшөөрлийг авч ил, далд ажлын актыг баталгаажуулж дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэнэ.
2. Авто зам, замын байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээ болон оршин суугчдын ая тухтай, аюулгүй зорчиход ямар нэгэн саад бэрхшээл учруулахгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах шаардлагатай.
3. Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.

Захиалагчийн хяналт:

1. Авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэж эхлэхээс дуусах хүртэлх бүх технологийн үйл ажиллагаа.
2. Батлагдсан ажлын зураг төсөл, норм, дүрэм, технологийн шаардлагыг зөрчсөн нөхцөлд захиалагч байгууллагын эрх бүхий төлөөлөгчид, техник технологийн хяналтын баг, мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчид барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Гүйцэтгэгч байгууллага:

1. Гүйцэтгэгч байгууллага нь ажлын зураг төсөл, төсөв, тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Ажлын талбайд журнал хөтөлж, захиалагч, хяналтын инженерийн өгсөн үүрэг даалгавар, шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гаргана.
3. Ажил гүйцэтгэх явцад үе шатны ажил тус бүрийг фото зургаар баталгаажуулан далд ажлын акт үйлдэнэ.
4. Ажлын явцад өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байгууламжуудыг нөхөн сэргээн засварлаж хэвийн байдалд оруулна.
5. Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшгаас сэргийлэн даатгалд бүрэн хамрагдан аюулгүй байдлыг хангаж ажиллана.
6. Ажлын явцад болон ажил гүйцэтгэж дуусахад гарсан хог хаягдлыг хогийн цэгт хаях ажлыг бүрэн хариуцна.
7. Авто зам талбай, замын байгууламжийн ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагч, технологийн хяналтын инженерийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд хийж гүйцэтгэсэн ажилдаа баталгаа гаргана.
8. Зам, замын байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэлийн зургаар баталгаажуулна.

9. Хэрвээ зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 14 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

Ерөнхий төлөвлөлт, техникийн үзүүлэлт, шийдэл, цар хүрээ, тавигдах шаардлага Гүйцэтгэгч дараах зүйлээс бүрдсэн ажлын төлөвлөгөөг захиалагчаар батлуулахаар танилцуулна.

1. Гүйцэтгэх ажлын нарийвчилсан график

2. Санхүүжилтийн хуваарь: Хуулийн дагуу урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлсэн тохиолдолд урьдчилгаа төлбөр олгож болно. Санхүүжилтийг үе шатаар гүйцэтгэлээр санхүүжүүлнэ. Гүйцэтгэлийн баталгаа шаардана. Авто замын тухай, Барилгын тухай хуульд заасны дагуу 3 жилийн хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийн барьцаа хөрөнгө суутгана.

3. Гүйцэтгэгч гэрээний баримт бичгүүдийг холбогдох байгууллагуудад танилцуулж авто замын барилга, байгууламжийн ажил эхлүүлэх зөвшөөрлийг тухай бүр авсан байна.

4. Гүйцэтгэгч нь Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “24 айл”, “60 айл” орчмын гадна зам талбай, Грийн таун хорооллын баруун талаас музейн урд талын 2-р тойргийн зам хүртлэх авто зам, замын байгууламжийн ажлыг тендерийн баримт бичиг, батлагдсан зураг төсөл, төсөв, ажлын тоо хэмжээний дагуу хийж гүйцэтгэнэ.

5. Байршил, одоо байгаа байдал: Сүхбаатар аймаг, Баруун-Урт хотын 1-р Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт “60 айл”, “24 айл”, “Баазын 8 айл”-ын орон сууцнуудын дундах зам, талбай, Грийн таун хорооллын баруун талаас музейн урд тал хүртэлх зам, байгуулахаар төлөвлөж буй талбай нь авто зам, явган зам, гэрэлтүүлэг байхгүй, ердийн шороон зам талбайтай, тоос шороо ихтэй, зуны улиралд бороо орсон үед хонхор, хотгор газруудад ус тогтдог, замын трассын доогуур холбооны шугам, цэвэр усны болон бохир усны, дулааны шугам сүлжээ ихтэй.

6. Төлөвлөлт: Баруун-Урт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /2015-2030 он/, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5.4.2

Дагуу болон хөндлөн огтлолын төлөвлөлтийг Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04, БНБД 32-01-04-ийн дагуу төлөвлөсөн.

- “24 айл”, “60 айл” орчмын гадна зам талбай: Ажлын зураг төсөлд хамрагдаж буй авто зам, зогсоолын нийт талбай 4377м² /гол зам 5,5 м өргөн 365 м урттай бетон хучилттай, туслах зах 5 м өргөн 264 м урттай бетон хучилттай, авто зогсоол 1050 м² бетон хучилттай, авто зам хашлага 1497м болно. Хөндлөн огтлолын хувьд ухмал 15см, хөрсийг нягтруулж, цементбетон хучилт 15см.
- Грийн таун хорооллын баруун талаас музейн урд талын 2-р тойргийн зам хүртлэх авто зам: замын нийт урт 370 м, замын далангийн өргөн 11.36, зорчих хэсгийн өргөн 6м, хөвөөний өргөн 05м, хучлагын бүтээц- Асфальтбетон 5 см, буталсан чулуун суурь 20 см, суурийн доод үе 30 см. Төлөвлөж байгаа замын гадаргуугийн усыг хөндлөн болон дагуу налуугаараа урсаж гарцуудаараа зайлуулагдахаар төлөвлөсөн байна.

Төлөвлөж буй авто зам, замын байгууламж ажлын зураг, төсөв, тайлбар бичиг, техникийн шаардлага, инженер геологийн судалгааны дүгнэлт, байр зүйн зургийн тайлангаас бүрдэнэ.

Тайлбар: Төлөвлөж буй 370м авто замын трассын дагууд холбоо, цахилгаан, дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээ ихтэй ба инженерийн шугам сүлжээний ашиглагч байгууллагуудтай зөвшилцөн санал авч цэвэр ус, дулааны шугамуудыг замын трассаас зайлуулж, хөндлөн огтолж буй хэсэгт хучилтын хийцийг явган хүний даацын хавтангаар хийхээр, замын дагууд давхцаж байгаа бохирын шугамыг явган замын доор байхаар төлөвлөсөн ба үзлэгийн хурдгийн тагийг хүчитгэн замын ижил түвшинд байхаар, цахилгааны өндрийн шугамтай огтлолцож буй хэсэгт 1ш шон өндөрлөхөөр, замын эхлэл хэсэгт 130 м трасстай давхцаж буй холбооны шугамыг шилжүүлэх, мөн 66 м хайш, хашлагыг шилжүүлэн барихаар төлөвлөж тоо хэмжээг төсөвт тусгасан болно.

Авто замын барилга байгууламжийн ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/, стандартыг баримтлан төсөвт тусгагдсан ажлуудыг орхигдуулахгүйгээр технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Үүнд:

- Авто замын уур амьсгалын геотехникийн нөхцөл АЗУАГН 2,01,01-2004
- Авто зам төсөллөх ЗЗБНБД22-004-2016
- Хот суурины гудамж замын төлөвлөлт БНБД32-01-07
- Газар хөдлөлтийн бүс нутаг барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНБД 22-01-01/2006
- Авто замын уян хучилтыг төсөллөх тооцооны аргачлал
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норм БД31-101-04
- Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014
- Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 4759:2014
- Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2014
- Бусад

Хөгжлийн бэрхшээлтэй /Тэргэнцэртэй/ иргэдэд зориулсан гарц, замын зорчих хэсэг болон уулзвар, гарцуудад төлөвлөнө.

Ажлын зураг, төсөвт тусгагдаагүй боловч зайлшгүй шаардлагаар нэмэлтээр хийгдэх шугам сүлжээний ажилтай холбоотойгоор зам талбай сэтлэх, шилжүүлэх зэрэг бусад ажлуудыг магадлашгүй ажлын зардлаар хийнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь: импортын материал худалдан авах тохиолдолд тохиролын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторын шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал "Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ", лабораторийн шинжилгээний дүн, падаан хавсаргана. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүнг барилгын хувийн хэрэгт хавсаргана.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ЭНХЦЭЦЭГ



Грийн таун хорооллын баруун талаас музейн урд талын 2-р тойргийн зам хүртлэх 370
у/м авто замын техникийн үзүүлэлтүүд:

д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Замын техникийн үзүүлэлтүүд
1	Замын ангилал		Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
2	Замын урт	м	370
3	Эргэлтийн тоо	ш	6
4	Хэвтээ муруйн хамгийн бага радиус	м	150
5	Хэвтээ муруйн хамгийн их радиус	м	180
6	Тойруугийн нийт урт	м	60
7	Тойруугийн трассад эзлэх хувь	%	16
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	2000
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	3000
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	3000
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	10000
12	Дагуугийн хамгийн их налуу	%	1,5
13	Дагуугийн хамгийн их налуутай хэсгийн үргэлжлэх урт	м	50
14	Гарцны хамгийн бага радиус		6
15	Замын далангийн өргөн	м	11.36
16	Зорчих хэсгийн өргөн	м	6
17	Замын хөндлөн налуу		2
18	Хөвөөний өргөн	м	0,5
19	Өндөрлөсөн далангийн хажуу налуу	m:n	1:1.5-1:3